

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны
2017 оны 02 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

“ТАЙВАН-АМГАЛАН-ХОВДЧУУД” ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА:

Эрх зүйн үндэслэл: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг, 19 дүгээр зүйлийн 2-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тусгажээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ байхаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 2 дугаар хуралдааны 2/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 4.4.1.8 дахь заалтад “Архи, тамхигүй айл өрх, албан газар, сум, баг болох хөдөлгөөн өрнүүлж, “Тайван-Амгалан-Ховдчууд” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэсэн зорилт тусгагдсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

Ховд аймгийн 2015, 2016 онуудын эрүүгийн нөхцөл байдлын дүн мэдээ, баримт нь иргэдийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг бэхжүүлэх, гарч буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэгдсэн бодлогоор зангидах шаардлагатайг харуулна.

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах хууль зүйн арга хэрэгсэл нь болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, уг ажилд иргэд, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагыг өргөнөөр оролцуулах, тэдний үйл ажиллагааг дэмжих, төр, захиргаа, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн нэгдсэн бодлого, чиглэлтэйгээр ажиллахад орших юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалахад чиглэсэн эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, Ховдчууд нутагтаа амгалан тайван амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ:

3. Хөтөлбөр нь тавьсан зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулж, тэдгээрийн ажлын уялдаа холбоог сайжруулах замаар чанартай, хүртээмжтэй, үр ашигтай зохион байгуулах ажлыг зохицуулах,

3.2. Архидан согтуурахын эсрэг, тамхины хор уршигтай тэмцэх талаар хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, архигүй, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, согтууруулах ундаа, тамхины хэрэглээнд зохистой, соёлтой хандлагыг төлөвшүүлэх,

3.3. Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх,

3.4. Насанд хүрээгүй хүмүүсийг хэрэг, зөрчил, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх,

3.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, зам тээврийн хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёлыг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх,

3.6. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг уялдуулан зохицуулж, уг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх оновчтой арга механизмыг хэрэгжүүлэх,

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

4. Хөтөлбөр нь тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх дараах үйл ажиллагааны чиглэлтэй байна. Үүнд:

4.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын чиглэлээр:

4.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж бүр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах,

4.1.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцох,

4.1.3. Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг бүрэн илрүүлж, учруулсан хохирол, гэм хорыг нөхөн төлүүлж, уг хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодруулан, тухай бүр арилгуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг заавал хэрэгжүүлж, хэвших,

4.1.4. Нийтийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл хэрэгт тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, их, дээд сургууль, коллеж, төрийн бус байгууллагын оролцоог бүх талаар дэмжиж, мэргэжлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцох,

4.1.5. Байгууллага, аж ахуйн нэгж, ахмад, эмэгтэйчүүд, оюутан, сурагчид зэрэг иргэд, олон нийтийн байгууллагыг олон нийтийн эргүүлд татан оролцуулж, үйл ажиллагааг нь дэмжин урамшуулах,

4.1.6. Нийтийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хор холбогдлын талаар нийтэд сурталчлан сэрэмжлүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага нийтлэл нэврүүлгийн бодлогыг чиглүүлж, мэдээллийн цагтай болох,

4.1.7. Гэмт хэрэг, зөрчилгүй, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж болох болзолт уралдааныг зохион байгуулж, тухайн чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудыг сурталчлах, дэмжих, урамшуулах,

4.1.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, санамж, зөвлөгөө, сурталчилгааг сонирхолтой хэлбэрээр бэлтгэж, онлайн эх сурвалжийг ашиглан олон нийтэд цацах ажлыг тогтмолжуулж, үр дүнг тооцох,

4.1.9. Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор сум тус бүр “Нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулж, хэвших,

4.1.10. Хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөрш зэргэлдээ аймгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жил бүр “Холболт” арга хэмжээг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох,

4.1.11. Жил бүрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажлын эмхэтгэл хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгох, мэдээллийн сан үүсгэх,

4.1.12. Аж ахуйн нэгж, байгууллага, гудамж, зам, талбайд гэрэлтүүлэг тавих, камержуулах, орчин тойрондоо аюул учруулж болзошгүй эзэнгүй нохойг устгах зэрэг ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах,

4.1.13. Төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн удирдлагын түвшинд “Тайван-Амгалан-Ховдчууд” хөтөлбөрийг танилцуулж, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх санал санаачилгыг өрнүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг ажил хэрэг болгох

4.1.14. Төр захиргаа, хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээгээ тодорхойлох

4.1.15. “Тайван-Амгалан-Ховдчууд” цахим хуудас ажиллуулах

4.1.16. Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх өөрийн эзэмшил нутаг дэвсгэрт хальтиргаа, гулгаа, нүх, шуудуу зэрэг осол, гэмтэлд хүргэж болох хүчин зүйлээс сэргийлж, аюулгүй орчин бүрдүүлэх, осол гарсан тохиолдолд тухайн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх хүлээх үүрэг, хариуцан гүйцэтгэх ажлыг зааглан тогтоох асуудлаар тусгай журам боловсруулж хэрэгжүүлэх,

4.2. Архигүй, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, согтууруулах ундаа, тамхины зохистой, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх

4.2.1. Орон нутгийн төр, захиргаа, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд архидан согтуурахын эсрэг, тамхины хор уршигтай тэмцэх талаар хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, төрийн байгууллагууд болон нийтийн эзэмшлийн зам талбай, үйлчилгээний бүх байгууллагуудад архигүй, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлэх

4.2.1.1. Сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, хамт олны ажлыг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх, Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын бодит үр дүнг харгалздаг болгох

4.2.1.2. Архигүй, тамхигүй орчин бий болгож, иргэдийг амгалан тайван, эрүүл аюулгүй орчинд аж төрөх нөхцөл бүрдүүлэхэд анхаарч зохих үр дүнд хүрсэн үлгэр жишээ сум, баг, байгууллага, хамт олныг шалгаруулан урамшуулах болзолт

уралдаан зарлаж, архи, тамхины хамааралгүй орчинд амьдарч, ажиллах уриалга гарган хэрэгжүүлж, аливаа баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг архигүй, тамхигүй цэвэр таатай орчинд тэмдэглэдэг, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зүй зохистой зөв боловсон өнгөрүүлэх, тааламжтай орчинг бүрдүүлж чадсан сум, баг, байгууллага, гэр бүл, хувь хүмүүсийг бүх талаар дэмжин урамшуулах арга хэмжээ авах

4.2.1.3. Байгууллагуудын дотоод журамд архигүй, тамхигүй орчин бүрдүүлэх, архидан согтуурсныг хөдөлмөрийн сахилгын ноцтой зөрчилд тооцох заалт оруулан, зөрчсөн этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх

4.2.1.4. Архи, тамхи худалдаалах, түүгээр үйлчлэхгүй байх захиргааны шийдвэрийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээний зөвшөөрлийг хязгаарлах, хүчингүй болгох эрх зүйн арга хэрэгсэлийг бүрэн ашиглан бодит ажил хэрэг болгох

4.2.1.5. Хүн амд ногдох архи, тамхины үйлчилгээний цэгийн тоог цөөрүүлэх, худалдаа үйлчилгээний байгууллагуудын цагийн хуваарийг шинэчлэн тогтоох, биелэлтэд тавих хяналтыг сайжруулах

4.2.1.6. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг хавтгайруулан олгохгүй байх, тусгай зөвшөөрлийг 1-ээс доош жилийн хугацаагаар олгох,

4.2.1.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх журмыг хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн найруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулах, хэрэгжүүлэх,

4.2.2. Архины хэт хамааралтай иргэдийн дэлгэрэнгүй судалгааг сум, баг бүрээр шинэчлэн гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тэднийг архины хамаарлаас ангижруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

4.2.2.1. Архи, тамхинаас гарах хүсэлтэй иргэдэд сургалт хийх, зөвлөн туслах замаар нөлөөлөх, тэднийг архины хамаарлаас ангижрах эмчилгээнд хамруулах ажлыг хариуцах эрүүл мэндийн байгууллага болон сайн дурын бүлэг, төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах

4.2.2.2. Сургалт, эмчилгээнд хамрагдаж архины хамаарлаас ангижирсан хүмүүст мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтуудад хамруулж, улмаар ажилд зуучлах, хөнгөлөлттэй зээл, тусламж олгох төсөл, хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

4.2.2.3. Архины хэт хамааралтай иргэдийг холбогдох байгууллагын санал, шийдвэрийг үндэслэн албадан эмчлэх байгууллагад хүргэх зардлын асуудлыг шийдвэрлэх

4.2.3. Иргэдэд, ялангуяа өсвөр залуу үе, оюутан, сурагчдад архи, тамхины хор уршгийн эсрэг зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн бүх төрлийн сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах

4.2.3.1. Олон нийтэд зориулсан тэр дундаа архи, тамхины хамаарал бүхий гэр бүл, иргэдийн хандлагыг өөрчлөх, эрүүл зөв амьдрах чиглэлийн сургалт, лекц яриа, уулзалт ярилцлага, хэлэлцүүлэг, сэдэвт аян зэрэг сурталчилгааны ажлуудыг тасралтгүй өргөнөөр зохион байгуулах

4.2.3.2. Боловсрол, соёл, урлаг, биеийн тамир спортын зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын орчинг архи, тамхигүй, цэвэр тохилог, харилцааны соёлтой байлгахад чиглэсэн тусгай журам гаргаж хэрэгжүүлэх.

4.2.3.3. Архи, тамхи хэрэглэдэггүй, амьдралын зөв хэвшилтэй болон архины хамаарлаас ангижирсан хүмүүсийн туршлага, зөвлөгөөг сурталчилах тэдний оролцоотойгоор архидан согтуурахаас болон тамхины хор хөнөөлөөс сэргийлэх сайн дурын бүлэг холбоо байгуулан ажиллах үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих

4.3. Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

4.3.1. Хохирогчийн аюулгүй байдлыг хангасан түр хамгаалах байр, нэг цэгийн төвийг ашиглалтанд оруулах,

3.2. Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

4.3.3. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг бууруулахын тулд уг асуудлын учир шалтгаан, хүрээ, нийгэм, эрх зүйн үйлчилгээг хэрхэн хүртэж байгаа талаархи мэдээлэл судалгааны санг орон нутгийн хэмжээнд бүрдүүлэх;

4.3.4. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх зорилго бүхий ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

4.3.5. Хохирогчийг чадавхижуулахад чиглэсэн ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

4.3.6. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.3.7. Гэр бүлийн хүчирхийллийн талаархи иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулах;

4.4. Насанд хүрээгүй хүмүүсийг хэрэг, зөрчил, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

4.4.1. Хүүхдийн үйлдэж буй тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, уг төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эцэг эх, сургууль, багш, сурган хүмүүжүүлэгч, сум, баг, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч нарын хүмүүжлийн үр нөлөөг дээшлүүлэх

4.4.2. Компьютер тоглоом нь хүүхдийн оюун сэтгэхүй, эрүүл мэнд, хүмүүжил төлөвшилд хэрхэн нөлөөлж байгаа талаар эрүүл мэнд, мэргэжлийн байгууллагуудын судалгаа, дүгнэлт хийсний үндсэн дээр дээрх газруудын ажиллах журам, цагийн хуваарь, ажлын байрны шаардлагад өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх

4.4.3. Сургууль завсардахаас сэргийлэх, нэг ч хүүхдийг боловсролын тогтолцооноос гадуур байлгахгүй, сургуулиас холдуулах, хөөх бодлого баримтлахгүй байх, сургууль хүүхдүүдийг ажил мэргэжлийн баримжаа олгох албан бус сургалтанд хамруулах ажлыг заавал хийх

4.4.4. Эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, гэр бүл рүү нь чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, эцэг, эх, асран хамгаалагчдын хүлээх хариуцлагыг нэмэгдүүлж, журамт үүргээ биелүүлээгүй эцэг, эхэд зохих хариуцлага тооцдог байх тогтолцоог бий болгох

4.4.5. Хүүхдийн гэмт хэрэг, зөрчил, осолд өртдөг гэмтлийн шалтгаан, нөхцөл, түүнээс сэргийлэх талаар эцэг, эх, хүүхдийн дунд сурталчилан таниулах ажлыг тогтмол зохион байгуулах

4.4.6. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, осол, гэмтлээс сэргийлэхэд эцэг, эх, сургууль, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.4.7. Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “Сургуулийн сэргийлэгч эргүүл”-ийн журмын хэрэгжилтийг хангуулах,

4.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр:

4.5.1. Аймгийн хэмжээнд гарч байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлийн бодит шалтгаан, нөхцөлүүдэд судалгаа, дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажилд аймаг, сум, баг, төр захиргаа, хууль хяналт, зам, тээвэр, боловсрол соёл, хүүхэд залуучууд, байгаль орчин, хэвлэл мэдээлэл, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

4.5.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд замын хөдөлгөөний дүрэм, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

сургалт явуулах, энэ чиглэлээр төрөл бүрийн уралдаан тэмцээн, арга хэмжээг байнга үе шаттайгаар зохион байгуулах

4.5.3. Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний огтлолцол ихтэй зарим зам, зорчих хэсэгт шинээр гэрлэн дохио суурилуулах, зарим уулзваруудын гэрлэн дохиог шинэчлэх, засварлах, гэрэл, замын тэмдэг, тэмдэглэгээний тоог олшруулах, гэрэл дохионы зохицуулалтыг сайжруулах, нягтрал ихтэй цэгүүдэд хурд сааруулагч хийх

4.5.4. Зам тээврийн осолд явган зорчигч, хүүхэд өртдөг цэг, газруудыг камержуулж, замын цагдаагийн тасгийн хяналтанд оруулах

4.5.5. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна талд автомашины зогсоол хийлгэх

4.5.6. Явган зорчигч, нийтийн тээврийн такси, бага оврын автобусны жолооч нарын хөдөлгөөнд оролцох, хууль тогтоомжийн заалтыг чанд биелүүлэх, сахилга, соёлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хяналтыг чангатгаж, энэ чиглэлээр сургалт, сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмжийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр, ялангуяа богино долгионы радио, телевизээр түгшээсэн, айлгаж, сүрдүүлсэн байдлаар бус сонирхолтой, анхаарал татахуйц хэлбэрээр хийж богино хугацааны давтамжтайгаар цацаж байх ажлыг тогтмолжуулах

4.5.7. Замын гэрэлтүүлгийн өнөөгийн түвшинг тоо, чанарын хувьд дээшлүүлж, шинэ гудамж, зам, хорооллуудыг заавал гэрэлтүүлэгтэй хүлээн авдаг журамд шилжих;

4.5.8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, стандарт, зам тээврийн осол гарч байгаа шалтгаан нөхцөл, тэдгээрээс үүссэн хохирлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж, хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх талаархи ажлын агуулга, хэлбэр, чанар, үр нөлөөг дээшлүүлэх;

4.6. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх чиглэлээр:

4.5.1. Хулгайн болон малын хулгайн сүлжээг судлан тогтоосны үндсэн дээр хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллага иргэд, олон нийтийн хүч, оролцоог авч зохион байгуулах

4.5.2. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд сум, багийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөл нь багийн хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн байцаагч, нийгмийн ажилтан, урамшилт эргүүл, орцны

жижүүр, оршин суугчид хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангуулах

4.5.3. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах арга барил эзэмших, хулгайн хэрэг үйлдэгдэх нөхцөл, бололцоог гаргахгүй байх, хөрөнгөө хамгаалах талаар санаачилга гаргаж ажиллах, дохиолол тавиулах, хаалга, цоожны бат бэх байдлыг хангах, сонор сэрэмжээ нэмэгдүүлэх зэргээр өөрсдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэн ажиллах, гэмт хэрэг гарах таатай нөхцөлийг бүрдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид тодорхой хариуцлага хүлээлгэж байх

4.5.4. Сууц өмчлөгчдийн холбоо, багуудтай хамтран гудамжны болон нийтийн эргүүл ажиллуулах журам боловсруулж, гудамж талбай, орон сууцыг байнгын гэрэлтүүлэг, жижүүртэй болгох, иргэдийг нийтийн эргүүлд гаргахдаа хулгай, ялангуяа орон байрны хулгай зонхилон үйлдэгддэг газар, цаг, хугацаанд ажиллуулж байх

4.5.5. Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, хил залгаа аймаг, сумдтай малын хулгайн гэмт хэргийн талаар хоорондын мэдээлэл солилцох, тодорхой авагдсан мэдүүллүүдийг шалгах, тэдгээрийн үйл хөдөлгөөн, байршилд байнгын хяналт тавьж ажиллах

4.5.6. Малын мах, арьс шир, түүхий эд авдаг, зардаг ченжүүд, иргэдийг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэхэд өргөнөөр татан оролцуулж, идэвх зүтгэл гаргаж тодорхой үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгож, олон нийтийн идэвхийг өрнүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байх

4.5.7. Малчид, мал бүхий иргэд малаа байнгын хариулгатай байлгах зорилгоор “Нөхөрлөл”, “Бүлэг” байгуулан ажиллах

4.5.8. Зах зээлд нийлүүлж байгаа мах, махан бүтээгдэхүүний эх үүсвэр, мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгох ажлыг тогтмолжуулах

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ

5.1. Хөтөлбөр нь аймгийн хэмжээнд хэрэгжих бөгөөд тус аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг 2017-2020 онуудад хэрэгжүүлнэ.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

Үндсэн эх үүсвэр

5.3.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал;

Бусад эх үүсвэр:

5.3.3. иргэн, хуулийн этгээдийн хандив;

5.3.4. гадаад улс, олон улсын байгууллагын тусламж, хандив;

5.3.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ, ТАЙЛАГНАХ

6.1. Хөтөлбөрийг чиглэл, арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхээр урьдчилан төсөөлж байна. Үүнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын чиглэлээр:

6.1.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны хүртээмж, чанар сайжирч, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байх

6.1.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, гэр бүлийн оролцоо нэмэгдсэн байх

6.1.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, олон нийтэд хүргэх тогтолцоо бүрдсэн байх,

6.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөрийн үр дүнг тооцсон байх,

6.1.5. Аж ахуйн нэгж, байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгаж, биелэлтийг илтгэсэн байх,

6.1.6. Байгууллага, аж ахуйн нэгж, ахмад, эмэгтэйчүүд, оюутан сурагчид зэрэг иргэд, олон нийтийн байгууллагыг олон нийтийн эргүүлд татан оролцуулж, үйл ажиллагааг нь дэмжин урамшуулах,

6.1.7. Нийтийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хор холбогдлын талаар нийтэд сурталчлан сэрэмжлүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага нийтлэл нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлж, мэдээллийн цагтай болох,

6.1.8. Гэмт хэрэг, зөрчилгүй, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжийг шагнаж, урамшуулсан байх,

6.1.9. “Холболт” арга хэмжээг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх,

6.1.10. Аж ахуйн нэгж, байгууллага, гудамж, зам, талбайд гэрэлтүүлэг тавих, камержуулах, орчин тойрондоо аюул учруулж болзошгүй эзэнгүй нохойг устгах зэрэг ажлыг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх,

6.1.11. Төр захиргаа, хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөний жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулагдсан байх,

6.1.12. “Тайван-Амгалан-Ховдчууд” цахим хуудас ажилласан эхэлсэн байх,

Архигүй, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, согтууруулах ундаа, тамхины зохистой, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр:

6.2.1. Архины хамааралтай иргэдийн талаар аймгийн хэмжээний дэлгэрэнгүй үнэн зөв судалгаатай болно.

6.2.2. Архины хамаарлаас ангижрах сургалт арга хэмжээ, эмчилгээнд хамрагдах иргэдийн оролцоо нэмэгдэж, архи, тамхины хор хөнөөлийн талаарх иргэдийн ойлголт сайжирна.

6.2.3. Архины хамааралтай иргэдийн тоо буурч, архидан согтуурах явдал, архинаас үүдэлтэй үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл сайжирсан байна.

6.2.4. Сум, байгууллага бүрт болон нийтийн эзэмшлийн газарт тамхи татах стандартын тусгай цэгийн тоо нэмэгдсэн байна.

6.2.5. Нийтийн эзэмшлийн болон үзвэр үйлчилгээний газруудад архи, тамхи хэрэглэдэггүй тохилог орчин бий болж, иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдсэн байна.

6.2.6. Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж болон өрх гэр бүл, иргэнд архигүй эрүүл орчин бүрдсэн байна.

6.2.7. Олон нийт архины хор хөнөөлийн талаар мэдлэгтэй болж олон нийтийн дунд эрүүл зөв амьдрах хандлага нэмэгдэнэ.

6.2.8. Архинд донтох өвчлөл буурч, эмчлэн эдгэрүүлсэн, архины асуудлаа шийдвэрлэж өөрчлөгдсөн иргэдийн тоо нэмэгдэнэ.

6.2.9. Архинд донтох өвчлөл эдгэрсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин тодорхой хувиар өсч, өрхийн орлого нэмэгдэнэ.

Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

6.3.1. Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэнд мэргэжлийн түвшинд шуурхай хамгаалагдах баталгаа бүрдэх,

6.3.2. Хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох мэргэжлийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлдэг болох

6.3.3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн ажлын цогц үйлчилгээг үзүүлэх төр ба иргэний нийгмийн байгууллагын салбар хоорондын сүлжээт тогтолцоо бий болж, хамтран ажиллах чадавхи, бүтэц, зохион байгуулалтын механизм бэхжиж, боловсронгуй, тодорхой, хүртээмжтэй болох,

6.3.4. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийллээс ангижрах урт, богино хугацааны нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээг хүртэх таатай орчин бүрдэх,

6.3.5. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд тусгайлсан цогц үйлчилгээг хүргэж, хүчирхийллээс хамгаалах нөхцөл боломж бүрдэх

6.3.6. Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий бүлгийг тусгайлан хүчирхийллээс хамгаалах нөхцөл бүрдэнэ

6.3.7. Хамт олон, хөрш зэрэг нийгмийн бичил хэсэг нь хүчирхийлэлд өртөгсдөд мэдрэмжтэй, хариуцлагатай хандах ухамсар төлөвшинэ.

6.3.8. Гэр бүлд хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага төлөвшин гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлнэ.

Насанд хүрээгүй хүмүүсийг хэрэг, зөрчил, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

6.4.1. Хүүхдийн үйлдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байх,

6.4.2. Компьютер тоглоомын газруудын ажиллах журам, цагийн хуваарь, ажлын байрны шаардлагад өөрчлөлт оруулах талаар шийдвэр гарсан байх,

6.4.3. Сургууль завсардсан хүүхдийн тоо буурсан байх, хүүхдийг ажил мэргэжлийн баримжаа олгох албан бус сургалтанд хамруулсан байх,

6.4.4. Эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдийн судалгаа, гарч тэдэнд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх,

6.4.5. Хүүхдийн гэмт хэрэг, зөрчил, осолд өртдөг гэмтлийн шалтгаан, нөхцөл, түүнээс сэргийлэх талаар эцэг, эх, хүүхдийн дунд сурталчилан таниулах ажлыг хэвшүүлэх,

6.4.6. Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “Сургуулийн сэргийлэгч эргүүл”-ийн журмын хэрэгжилтийг хангагдсан байх,

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр:

6.5.1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч байгаа хохирлын хэмжээ буурна.

6.5.2. Замын хөдөлгөөний зохион байгуулалт, замын нөхцөл сайжирч, хөдөлгөөнд соёлтой оролцох таатай орчин бүрдэнэ.

6.5.3. Замын хөдөлгөөнд оролцогчид болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагч, албан тушаалтны мэдлэг, чадвар, хариуцлага дээшилнэ.

6.5.4. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан, нөхцөл, орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээг нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх чиглэлээр:

6.6.1. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулснаар хулгайн гэмт хэргийн гаралтыг сааруулан, нийт гэмт хэрэгт түүний эзлэх хувийг бууруулан, илрүүлэлт, хохирол нөхөн төлөлтийг дээшлүүлэх

6.6.2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага өмч хөрөнгийн хамгаалалтаа сайжруулан хулгайд өртөхгүй байх арга хэмжээ авдаг болсон байх.

6.6.3. Нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллага хамтран иргэд, төрийн бус байгууллагыг хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд зохион байгуулан оролцуулж, тэдгээрийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих.

6.6.4. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцдэг цагдаагийн албадыг мэдээллийн техник, холбоо, унаагаар зохих түвшинд хангаж, ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлэх

6.7. Хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

Нийтлэг шалгуур:

6.7.1. Гэмт хэрэг, зөрчлийн бууралт

6.7.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн сургалт, сурталчилгааны ажлын тоо, хүртээмж

6.7.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар авсан арга хэмжээний тайлан

6.7.4. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар бичигдсэн мэдэгдэл, шаардлагын тоо

6.7.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл хэрэгт иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, их дээд сургууль, коллеж, төрийн бус байгууллагын оролцооны байдал

6.7.6. Олон нийтийн байгууллагыг олон нийтийн эргүүлд гарсан хүний тоо, тэдгээрт олгосон урамшууллын хэмжээ,

6.7.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан нийтлэл, нэвтрүүлгийн тоо,

6.7.8. Гэмт хэрэг, зөрчилгүй, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжийн тоо, урамшууллын хэмжээ

6.7.9. Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой “Нээлттэй өдөрлөг”-ийн тоо, хүртээмж,

6.7.10. “Холболт”, “Хууль сахиулах байгууллагуудын зөвлөгөөн”-ний тоо

6.7.11. Эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажлын эмхэтгэл хэвлүүлийн тоо,

6.7.12. Аж ахуйн нэгж, байгууллага, гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг, камерын тоо, устгасан эзэнгүй нохойн тоо,

6.7.16. “Тайван-Амгалан-Ховдчууд” цахим хуудсанд тавигдсан мэдээллийн агуулга, хүртээмж

Тусгай шалгуур:

6.8.1. Архи, тамхигүй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн төсөвт болон аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь

6.8.2. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг төсөвт болон аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын тоо нэмэгдсэн байдал

6.8.3. Архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийн өсөлт, хамрагдсан хүний тоо

6.8.4. Архины хамаарлаас гарсан, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулсан байдал,

6.8.5. Зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангах, байнгын болон түр ажлын байранд зуучлах, нийтийг хамарсан ажилд оролцуулсан байдал

6.8.6. Эрүүлжүүлэгдсэн хүний тоо бууралт хувиар /өмнөх оны үр дүнтэй харьцуулсан бууралтын хувь/

6.8.7. Согтуугаар үйлдэгдсэн, зам тээврийн осол, бусдын эд хөрөнгийг хулгайлах, гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй, насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн бууралт нийт гэмт хэрэгт эзлэх хувиар

6.8.8. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн өмнөх онтой харьцуулсан бууралт/

6.8.9. Сум, байгууллага бүрт болон нийтийн эзэмшлийн газарт тамхи татах стандартын тусгай цэгийн тоо

6.8.10. Архигүй, тамхигүй орчин бүрдүүлж, шагнал урамшуулал авсан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо

6.8.11. Архи, тамхины хор хөнөөлөөс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо

6.8.12. Хохирогчийн аюулгүй байдлыг хангасан түр хамгаалах байр, нэг цэгийн төв

6.8.13. Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн үйл ажиллагаа

6.8.14. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх, хохирогчийг чадавхижуулахад чиглэсэн зорилго бүхий ухуулга, сурталчилгааны тоо, хүртээмж

6.8.15. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлсэн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа, өмгөөллийн ажлын тоо, хүртээмж

6.8.16. Компьютер тоглоомын газрын ажиллах журмын хэрэгжилтийн байдал

6.8.17. Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “Сургуулийн сэргийлэгч эргүүл”-ийн журмын хэрэгжилтийг хангуулах,

6.3.18. Зам, зорчих хэсэгт тавигдсан гэрлэн дохио, замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагчийн тоо,

6.8.19. Зам тээврийн осолд явган зорчигч, хүүхэд өртдөг цэг, газруудад тавигдсан камерын тоо

6.8.20. Авто машины зогсоолын хэмжээ, талбай, тоо

6.8.21. Хулгайн гэмт хэргийн нийт гэмт хэрэг эзлэх хувийн бууралт

5.3. Тайлагнах, дүгнэх:

5.3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаарх тайлан мэдээг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлнэ.

5.3.2. Аймгийн ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлыг нэгтгэн дүгнэж, Засаг даргын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсний үндсэн дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны... дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт



“ТАЙВАН-АМГАЛАН-ХОВДЧУУД” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлын чиглэл	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага		Төсөв /сая төгрөг/	Эх үүсвэр
			Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч		
Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын чиглэлээр:						
1	Аж ахуйн нэгж, байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцох,	2017-2020	Цагдаагийн газар	Байгууллага, аж ахуйн нэгж	-	Байгууллагын төсөв
2	Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг бүрэн илрүүлж, учруулсан хохирол, гэм хорыг нөхөн төлүүлж, уг хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээг заавал хэрэгжүүлэх	2017-2020	Цагдаагийн газар	Байгууллага, аж ахуйн нэгж	-	Байгууллагын төсөв,
3	Тухайн нутаг дэвсгэрийн бүх байгууллага, аж ахуйн нэгжийг нийтийн эргүүлд татан оролцуулж, олон нийтийн эргүүлийг урамшуулах	2017-2020	Цагдаагийн газар	Байгууллага, аж ахуйн нэгж	10	ГХУСА33-ын зардал
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн цагдааг дэмжих, урамшуулах	2017-2020	ГХУСА33 Хууль, эрх зүйн хэлтэс	Цагдаагийн газар	10	ГХУСА33-ын зардал
5	Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах “Нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулж, хэвших,	2017-2020	Цагдаагийн газар, Сумдын ЗДТГ	Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	-	Байгууллагын төсөв

6	Хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөрш зэргэлдээ аймгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жил бүр "Холболт" арга хэмжээг зохион байгуулах	2017-2020	Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	10	Орон нутгийн төсөв
7	Гудамж, зам, талбайд гэрэлтүүлэг тавих, орчин тойронд аюул учруулж болзошгүй эзэнгүй нохойг устгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2017-2020	Хот тохижуулах газар	Сумдын ЗДТГ	/төсөвт өртөг/	Улс, орон нутгийн төсөв
8	"Тайван-Амгалан-Ховдчууд" цахим хуудас ажиллуулах	2017-2020	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар	ГХУСА33	4	Хөтөлбөрийн зардлаас
9	Ховд аймгийн төвийг камержуулж, телекамерын хяналтанд авч, гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэх	2017-2020	Жаргалант сумын ЗДТГ Хот тохижуулах газар	Цагдаагийн газар	Төсөвт өртөг	Улс, орон нутгийн төсөв
10	Байршил тогтоох GPS төхөөрөмж, нисдэг камер Dron, шалгах багаж, энгэрийн камераар цагдаагийн албыг хангах	2017-2020	ГХУСА33 Аймгийн ЗДТГ	Цагдаагийн газар	40	Улс, орон нутгийн төсөв
11	Цагдаагийн газрын барилгын өргөтгөл, зарим сумдын цагдаагийн кобан, постын байрыг барих	2017-2020	Цагдаагийн газар Сумдын ЗДТГ	ГХУСА3 Аймгийн ЗДТГ	Төсөвт өртөг	Улс, орон нутгийн төсөв
12	"Тайван-Амгалан-Ховдчууд" хөтөлбөрийг танилцуулга, сургалтын материал бэлдэх, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх санал санаачилгыг өрнүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулах,	2017-2020	ГХУСА33 Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	Цагдаагийн газар Эрүүл мэндийн газар	6	Хөтөлбөрийн санхүүжилт Хандив, тусламж
Хоёр. Архигүй, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, согтууруулах ундаа, тамхины зохистой, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр:						
1	Архигүй, тамхигүй орчин бий болгож, иргэдийг амгалан тайван, эрүүл аюулгүй орчинд аж төрөх нөхцөл бүрдүүлэхэд анхаарч зохих үр дүнд хүрсэн үлгэр жишээ сум, баг, байгууллага хамт олныг шалгаруулан урамшуулах болзолт уралдаан зарлаж, архи, тамхины хамааралгүй орчинд амьдарч, ажиллах уриалга гарган хэрэгжүүлж,	2017-2020	ГХУСА3 Зөвлөл Цагдаагийн газар	Сумдын ЗДТГ	4	ГХУСА33 зардал

	аливаа баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг архигүй, тамхигүй цэвэр таатай орчинд тэмдэглэдэг, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зүй зохистой зөв боловсон өнгөрүүлэх, тааламжтай орчинг бүрдүүлж чадсан сум, баг, байгууллага, гэр бүл, хувь хүмүүсийг бүх талаар дэмжин урамшуулах арга хэмжээ авах					
2	Байгууллагуудын дотоод журамд архигүй, тамхигүй орчин бүрдүүлэх заалт оруулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах	2017-2020	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	Аж ахуйн нэгж, байгууллага	-	-
3	Архи, тамхи худалдаалах, түүгээр үйлчлэхгүй байх захиргааны шийдвэрийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээний зөвшөөрлийг хязгаарлах, хүчингүй болгох, эрх зүйн арга хэрэгслийг бүрэн ашиглах	2017-2020	Цагдаагийн газар Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ	-	-
4	Хүн амд ногдох архи, тамхины үйлчилгээний цэгийн тоог цөөрүүлэх, тусгай зөвшөөрөл олгохдоо нутаг дэвсгэрийн хүн амд ногдох согтууруулах ундаа худалдан борлуулах үйлчлэх цэгийн хязгаарыг баримтлах	2017-2020	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар	-	-
5	Сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, хамт олны ажлыг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх, тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын бодит үр дүнг харгалздаг болгох	2017-2020	ГХУСАЗЗ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Цагдаагийн газар Эрүүл мэндийн газар	-	-
6	Архидан согтуурсан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох нэгдсэн зөвлөлгөөн зохион байгуулж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх	2017-2020	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар	Эрүүл мэндийн газар Сумдын ЗДТГ	5	Хөтөлбөрийн санхүүжилт
7	Архи, тамхинаас гарах хүсэлтэй иргэдэд сургалт зохион байгуулах, зөвлөн туслах замаар нөлөөлөх, архины хамаарлаас ангижрах эмчилгээнд хамруулах ажлыг хариуцан хийх эрүүл мэндийн байгууллага болон сайн дурын бүлэг, төрийн бус	2017-2020	Эрүүл мэндийн газар Цагдаагийн газар Сайн дурын ТББ	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс Сумдын ЗДТГ	10	Хөтөлбөрийн санхүүжилт

	байгууллагуудад гэрээний үндсэн дээр төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах					
8	Зорилтот бүлгийг сэтгэл засал, хордлого тайлах эмчилгээ, архины хэт хамааралтай иргэдийг холбогдох байгууллагын санал, шийдвэрийг үндэслэн албадан эмчилгээнд хамруулах	2017-2020	Эрүүл мэндийн газар, Сайн дурын ТББ Цагдаагийн газар	Нийгмийн бодлогын хэлтэс Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	8	Хөтөлбөрийн санхүүжилт хандив дэмжлэг
9	Сургалт, эмчилгээнд хамрагдаж архины хамаарлаас ангижирсан хүмүүст мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтад хамруулж, улмаар ажилд зуучлах, хөнгөлөлттэй зээл, тусламж олгох төсөл, хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2017-2020	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	Сумдын ЗДТГ Их, дээд сургууль	5	Улс, орон нутгийн төсөв, Хандив, дэмжлэг
10	Олон нийтэд зориулсан тэр дундаа архи, тамхины хамаарал бүхий гэр бүл, иргэдийн хандлагыг өөрчлөх, эрүүл зөв амьдрах чиглэлийн сургалт, лекц яриа, уулзалт, хэлэлцүүлэг, сэдэвт аян зэрэг сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2017-2020	Хууль, эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар Сумдын ЗДТГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Эрүүл мэндийн газар	8	Хөтөлбөрийн санхүүжилт Хандив, дэмжлэг
11	Боловсрол, соёл, урлаг, биеийн тамир спортын зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын орчинг архигүй тамхигүй, цэвэр тохилог, харилцааны соёлтой байлгахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх	2017-2020	Боловсрол, соёл, урлагийн газар Биеийн тамир, спортын газар	Сумдын Засаг даргын Тамгын газар	-	Байгууллагын төсв
12	Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр цагдаагийн байгууллагыг хангах, эрх нь хасагдсан жолооч нарт зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2017-2020	Цагдаагийн газар Жолооны сургалтын төв	Сумдын ЗДТГ	4	Төсөв, хандив тусламж
13	Архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүмүүс, орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг болон орон гэргүй архичид, согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргаж, цахим мэдээллийн	2017-2020	Цагдаагийн газар Эрүүл мэндийн газар	ГХУСАЗЗ Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	-	-

	сан, сүлжээ бүрдүүлэн архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтанд ашиглах					
15	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аймаг, сумдын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан, хяналт шалгалт явуулж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах	2017-2020	ХОХБТХ Цагдаагийн газар Мэргэжлийн хяналтын газар,	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	4	Хөтөлбөрийн санхүүжилтээс
Гурав. Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:						
1	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангасан түр хамгаалах байр, нэг цэгийн төвийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажиллуулах	2017-2020	Хууль, эрх зүйн хэлтэс Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Аймгийн ЗДТГ	Төсөвт өртөг	Орон нутгийн төсөв
2	Хараа хяналтгүй, төөрсөн, орон гэрээсээ дайжсан хүүхдүүд, зан төлөвийн доголдолтой гэр бүлийн гишүүдэд хандсан эрүүл мэнд, нийгмийн ажил, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;	2017-2020	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Цагдаагийн газар	ГХУСАЗСЗ Аймгийн ЗДТГ	4	Орон хөгжлийн сан/хамтарсан багийн зардал/
3	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг чадавхижуулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх зорилго бүхий чиглэсэн ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2017-2020	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Цагдаагийн газар	ГХУСАЗСЗ Аймгийн ЗДТГ	4	ГХУСАЗСЗ зардал Орон хөгжлийн сан/хамтарсан багийн зардал/
Дөрөв. Насанд хүрээгүй хүмүүсийг хэрэг, зөрчил, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:						
1	Хүүхдийн үйлдэж буй тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, уг төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эцэг эх, сургууль, багш, сурган хүмүүжүүлэгч, сум, баг, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч нарын хүмүүжлийн үр нөлөөг дээшлүүлэх, тэдгээрийн	2017-2020	Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар Цагдаагийн газар	ГХУСАЗСЗ Сумдын ЗДТГ	-	-

	тодорхой төлөвлөгөөтэйгээр ажиллуулах					
2	Цахим тоглоомын газрын ажиллах журмыг шинэчлэн хэрэгжүүлэх, тухайн үйл ажиллагаа эрхэлдэг газруудад хийх хяналт шалгалтыг тогмолжуулах	2017-2020	Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар Цагдаагийн газар	Аймгийн ИТХ Аймгийн ЗДТГ	-	-
3	Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “Сургуулийн сэргийлэгч эргүүл”-ийн журмын хэрэгжилтийг хангуулах,	2017-2020	Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар Цагдаагийн газар	ГХУСА33 Аймгийн ЗДТГ	-	ГХУСА33-ийн зардал
4	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхижүүлж, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар нарийвчилсан төлөвлөгөө хэрэгжүүлэх	2017-2020	Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар Цагдаагийн газар	ГХУСА33 Аймгийн ЗДТГ	-	Хандив, тусламж Бусад эх үүсвэр
5	Хурдан морины цуралдааны үеэр унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг хамтарсан багийн хэлбэрээр үзүүлэх замаар хүүхдийн осол, эндэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	2017-2020	Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар Цагдаагийн газар	ГХУСА33 Аймгийн ЗДТГ	-	Орон хөгжлийн сан/хамтарсан багийн зардал/
Тав. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр:						
1	Аймгийн хэмжээнд гарч байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлийн бодит шалтгаан, нөхцөлүүдэд судалгаа, дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах	2017-2020	Цагдаагийн газар Сумдын ЗДТГ	ГХУСА33	-	ГХУСА33 зардал
2	Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний огтлолцол ихтэй зарим зам, зорчих хэсэгт шинээр гэрлэн дохио суурилуулах, зарим уулзваруудын гэрлэн дохиог шинэчлэх, засварлах, гэрэл, замын тэмдэг, тэмдэглэгээний тоог олшруулах, нягтрал ихтэй цэгүүдэд хурд сааруулагч хийх	2017-2020	Цагдаагийн газар “Ховд-Азза” ТӨҮГ АТҮТ-ын Ховд салбар	ГХУСА33 Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	Төсөвт өртөг	Улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр

3	Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх агуулга бүхий мэдээлэл, сурталчилгааны самбарыг орон нутгийн, улсын чанартай замд байршуулах	2017-2020	Цагдаагийн газар, Албан журмын даатгалын холбоо,	Даатгалын компаниудын салбарууд	Төсөвт өртөг	Улс, орон нутгийн төсөв Бусад эх үүсвэр
4	Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрыг ашиглалтанд оруулж, ачилтын тээврийн хэрэгсэл, хурд хэмжигч, бэлэн бус торгуулийн машин, дугуй цоожлогчоор хангах замаар зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах	2017-2020	Цагдаагийн газар	ГХУСА33	Төсөвт өртөг	Улс, орон нутгийн төсөв Бусад эх үүсвэр
5	Ховд аймгийн нутаг дэвсгэр дахь орон нутгийн болон улсын, олон улсын чанартай автозамд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	2017-2020	Цагдаагийн газар	ГХУСА33	20	Төсвийн хөрөнгө Бусад эх үүсвэр
6	Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэр дахь хөдөлгөөний ачаалал бүхий уулзвар замуудад гэрлэн дохио кобан буюу суурин постуудыг байршуулах	2017-2020	Цагдаагийн газар Жаргалант сумын ЗДТГ	ГХУСА33	Төсөвт өртөг	Төсвийн хөрөнгө Бусад эх үүсвэр
7	"School police" хөтөлбөрийг хэрэгжүүлж, биелэлтийг нь ханган ажиллах	2017-2020	Цагдаагийн газар Боловсрол, соёл, урлагийн газар	ГХУСА33	10	ГХУСА33 зардлаас
8	Улсын хэмжээнд Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Ногоон гэрэл, цагаан шугам" тэмцээнийг зохион байгуулж, хэвших	2017-2020	Цагдаагийн газар Боловсрол, соёл, урлагийн газар	ГХУСА33	8	ГХУСА33 зардлаас
9	Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна талд автомашины зогсоол хийлгэх	2017-2020	Байгууллага, аж ахуйн нэгж	Цагдаагийн газар Авто тээврийн салбар	-	Бусад эх үүсвэр
Зургаа. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх чиглэлээр:						
1	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах арга барил эзэмших, хулгайн хэрэг үйлдэгдэх нөхцөл, бололцоог гаргахгүй байх, хөрөнгөө хамгаалах талаар санаачилга гаргах, дохиолол тавиулах, хаалга, цоожны бат бэх байдлыг хангах, сонор сэрэмжээ нэмэгдүүлэх зэргээр өөрсдийн үүрэг хариуцлагыг	2017-2020	Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ ГХУСА33	-	-

	өндөржүүлэн ажиллах, гэмт хэрэг гарах таатай нөхцөлийг бүрдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид тодорхой хариуцлага хүлээлгэж байх					
2	Иргэдийг нийтийн эргүүлд татан оролцуулахдаа хулгай, ялангуяа орон байрны хулгай зонхилон үйлдэгддэг газар, цаг, хугацаанд ажиллуулж байх	2017-2020	Сум, багийн Засаг дарга, Сууц өмчлөгчдийн холбоо	Сумдын ЗДТГ	-	ГХУСАЗЗ-ын зардал
3	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж, эрчимжүүлэх Баруун бүсийн сургалт, зөвлөгөөнд хамрагдаж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийг тодорхойлох	2017-2020	Цагдаагийн газар	ГХУСАЗСЗ Хууль зүйн хэлтэс,	2	Хөтөлбөрийн санхүүжилтээс
4	“Малчдын бүлэг, нөхөрлөл”, “Морин-Эрүүл” ажиллах журмыг батлан хэрэгжүүлж, хулгайн гэмт хэрэгт олон нийтийн оролцоог идэвхижүүлэх, үр дүнтэй ажилласан эргүүл, малчдын бүлгийг урамшуулах	2017-2020	Цагдаагийн газар Сумдын ЗДТГ	ГХУСАЗСЗ Аймгийн ИТХ	4	ГХУСАЗЗ-ийн зардал
5	Малын мах, арьс шир, түүхий эд авдаг, зардаг ченжүүд, иргэдийг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэхэд өргөнөөр татан оролцуулж, идэвх зүтгэл гаргаж тодорхой үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгох	2017-2020	ГХУСАЗСЗ Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	3	ГХУСАЗЗ-ийн зардал

...оОо...